БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/16/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Назгүл<br>Утас: 88403281 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 12

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 15

**4.1 Ерөнхий зүйл** ..... 15

**4.2 Материаллаг байдал** ..... 16

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 16

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 16

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 16

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 17

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 17

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 17

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 17

**5.1 Төлбөрийн акт** ..... 17

**5.2 Албан шаардлага** ..... 17

**5.3 Зөвлөмж** ..... 17

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТТӨХ | Тоног төхөөрөмж |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.08 № 68
танай ____________-ны № ____________-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
М.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

00402093

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,251,160.25** | **49,699,798.10** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,251,160.25 | 49,699,798.10 |
| **351** | **Түүхий эд материал** | 21,029,433.00 | 8,235,474.65 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,806,973.00 | 6,804,544.65 |
| 35130 | Эм боох материал | 2,222,460.00 | 1,430,930.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,098,836.25 | 3,797,047.45 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,122,891.00 | 37,667,276.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | 19,107,860.00 | 25,328,460.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 803,320.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 760,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 3,255,031.00 | 365,496.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 11,170,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **194,841,147.29** | **202,277,485.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 194,841,147.29 | 202,277,485.70 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 152,133,147.29 | 118,235,485.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 21,683,256.70 | 21,683,256.70 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (5,585,882.88) | (6,982,353.60) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 149,235,891.00 | 62,135,891.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (85,733,333.57) | (25,772,648.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,624,343.00 | 88,860,701.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (53,747,432.48) | (45,403,920.72) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,062,952.00 | 35,943,622.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,565,446.48) | (16,387,862.16) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 4,158,800.00 | 4,158,800.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 42,708,000.00 | 84,042,000.00 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,417,692.31) | (6,417,692.31) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 42,708,000.00 | 84,042,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **243,092,307.54** | **251,977,283.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **243,092,307.54** | **251,977,283.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 243,092,307.54 | 251,977,283.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 126,241,246.90 | 126,241,246.90 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 97,845,227.51 | 106,730,203.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 97,845,227.51 | 97,845,227.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 8,884,976.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,005,833.13 | 19,005,833.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **243,092,307.54** | **251,977,283.80** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **715,766,236.26** | **1,027,608,433.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **61,226,336.26** | **59,310,733.49** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 61,226,336.26 | 59,310,733.49 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 60,726,336.26 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 60,726,336.26 | |
| 120009 | Бусад орлого | 500,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 41,334,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 17,976,733.49 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **654,539,900.00** | **968,297,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 631,539,900.00 | 929,686,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 631,539,900.00 | 929,686,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,000,000.00 | 38,611,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | 34,950,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,500,000.00 | 3,661,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **677,282,786.40** | **1,018,723,457.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **677,282,786.40** | **1,018,723,457.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 672,608,812.00 | 997,118,332.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 478,580,038.39 | 745,222,927.97 |
| 210101 | Үндсэн цалин | 303,787,200.00 | 458,978,058.71 |
| 210102 | Нэмэгдэл | 165,638,113.05 | 245,771,685.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,094,138.39 | 21,494,200.00 |
| 210104 | Урамшуулал | 8,060,586.95 | 18,978,983.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,527,787.21 | 14,796,247.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,527,787.21 | 14,796,247.64 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,734,700.00 | 57,773,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,611,100.00 | 10,125,195.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,254,000.00 | 36,652,257.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,369,600.00 | 4,995,948.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,500,000.00 | 6,000,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,176,083.01 | 57,290,079.95 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,846,500.00 | 3,015,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,176,300.00 | 33,261,980.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,456,900.00 | 2,850,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 73,200.00 | 73,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,529,895.01 | 1,277,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,093,288.00 | 16,811,999.95 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,857,264.90 | 32,160,915.69 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 891,480.00 | 757,830.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,965,784.90 | 30,389,535.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,013,550.69 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,159,850.00 | 18,246,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,159,850.00 | 18,246,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 744,000.00 | 4,900,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 744,000.00 | 4,900,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,382,700.00 | 8,556,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,101,300.00 | 1,905,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 222,200.00 | 412,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 111,000.00 | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 840,500.00 | 5,090,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 107,700.00 | 1,004,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,446,388.49 | 58,171,561.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,290,000.00 | 12,387,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,600.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,005,788.49 | 45,683,661.59 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,673,974.40 | 21,605,124.39 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,814,000.00 | 18,852,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 17,882,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,814,000.00 | 970,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 859,974.40 | 2,752,724.39 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | - | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 859,974.40 | 2,752,724.39 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **38,483,449.86** | **8,884,976.26** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **38,483,449.86** | **8,884,976.26** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **655,039,900.00** | **968,297,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **500,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 500,000.00 | - |
| 120009 | Бусад орлого | 500,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **654,539,900.00** | **968,297,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 631,539,900.00 | 929,686,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 631,539,900.00 | 929,686,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,000,000.00 | 38,611,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | 34,950,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,500,000.00 | 3,661,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **645,652,200.00** | **956,511,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **645,652,200.00** | **956,511,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **641,478,225.60** | **934,906,575.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 479,080,038.39 | 745,222,927.97 |
| 210101 | Үндсэн цалин | 304,287,200.00 | 458,978,058.71 |
| 210102 | Нэмэгдэл | 165,638,113.05 | 245,771,685.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,094,138.39 | 21,494,200.00 |
| 210104 | Урамшуулал | 8,060,586.95 | 18,978,983.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,527,787.21 | 14,796,247.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,527,787.21 | 14,796,247.64 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,734,700.00 | 57,773,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,611,100.00 | 10,125,195.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,254,000.00 | 36,652,257.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,369,600.00 | 4,995,948.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,500,000.00 | 6,000,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,769,700.00 | 40,088,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,563,300.00 | 2,600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,176,300.00 | 34,065,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,456,900.00 | 2,850,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 73,200.00 | 73,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 35,639,900.00 | 28,371,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 871,800.00 | 871,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,768,100.00 | 27,500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,236,500.00 | 22,387,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,444,500.00 | 7,614,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,792,000.00 | 14,773,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 744,000.00 | 4,900,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 744,000.00 | 4,900,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,518,900.00 | 8,880,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,237,500.00 | 2,229,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 222,200.00 | 412,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 111,000.00 | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 840,500.00 | 5,090,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 107,700.00 | 1,004,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,226,700.00 | 12,486,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,028,100.00 | 12,287,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 198,600.00 | 198,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,173,974.40** | **21,605,124.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,314,000.00 | 18,852,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 17,882,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,314,000.00 | 970,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 859,974.40 | 2,752,724.39 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 859,974.40 | 2,752,724.39 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,387,700.00** | **11,786,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,387,700.00** | **11,786,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,387,700.00** | **11,786,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,387,700.00 | 11,786,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,387,700.00 | 11,786,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(9,387,700.00)** | **(11,786,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 126,241,246.90 | 19,005,833.13 | 97,845,227.51 | | 243,092,307.54 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **97,845,227.51** | - | 243,092,307.54 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **97,845,227.51** | - | 243,092,307.54 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **97,845,227.51** | - | 243,092,307.54 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **97,845,227.51** | - | 243,092,307.54 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 8,884,976.26 | | 8,884,976.26 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **106,730,203.77** | - | 251,977,283.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 929,686,200.00 | 926,933,475.61 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 929,686,200.00 | 926,933,475.61 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 910,833,800.00 | 908,081,075.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 745,229,400.00 | 745,222,927.97 |
| 210101 | Үндсэн цалин | 451,508,900.00 | 458,978,058.71 |
| 210102 | Нэмэгдэл | 251,257,700.00 | 245,771,685.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,445,000.00 | 21,494,200.00 |
| 210104 | Урамшуулал | 19,017,800.00 | 18,978,983.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,542,500.00 | 14,796,247.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,542,500.00 | 14,796,247.64 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,773,400.00 | 51,773,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,024,100.00 | 10,125,195.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,649,300.00 | 36,652,257.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,100,000.00 | 4,995,948.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,088,500.00 | 35,088,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,600,000.00 | 2,600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,065,300.00 | 29,065,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,850,000.00 | 2,850,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 73,200.00 | 73,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,371,800.00 | 28,371,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 871,800.00 | 871,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,500,000.00 | 27,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,161,500.00 | 14,161,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,500,000.00 | 6,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,661,500.00 | 7,661,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,900,000.00 | 4,900,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,900,000.00 | 4,900,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,880,600.00 | 8,880,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,229,600.00 | 2,229,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 412,800.00 | 412,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143,000.00 | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,090,500.00 | 5,090,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,004,700.00 | 1,004,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,886,100.00 | 4,886,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,687,500.00 | 4,687,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 198,600.00 | 198,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,852,400.00 | 18,852,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,852,400.00 | 18,852,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,882,400.00 | 17,882,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 970,000.00 | 970,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 929,686,200.00 | 926,933,475.61 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 929,686,200.00 | 926,933,475.61 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 929,686,200.00 | 926,933,475.61 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **23,000,000.00** | **38,611,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **23,000,000.00** | **38,611,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 23,000,000.00 | 38,611,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,500,000.00 | 6,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,500,000.00 | 6,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 5,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 5,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 17,611,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 10,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 7,111,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,500,000.00 | 10,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,500,000.00 | 10,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 23,000,000.00 | 38,611,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,000,000.00 | 38,611,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | 34,950,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,500,000.00 | 3,661,500.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ял эдлүүлэх чиглэлээр шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх, иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр болон бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тайлант онд “Алба хаагчдын хөгжлийг дэмжиж, шинийг санаачлан, шуурхай үйлчилгээг эрхэмлэх жил” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2023 онд бусад эрх бүхий байгууллагаас шалгалт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Шүүхийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.9 сая төгрөгөөр буюу 103.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 48,251.20 | 49,699.80 | 1,448.60 |
| Үндсэн хөрөнгө | 194,841.10 | 202,277.50 | 7,436.40 |
| **Нийт хөрөнгө** | **243,092.30** | **251,977.30** | **8,885.00** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 243,092.30 | 251,977.30 | 8,885.00 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **243,092.30** | **251,977.30** | **8,885.00** |

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гараагүй бол бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд бага хэмжээний өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 1.4 сая төгрөгөөр өссөн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 18.0 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй шилжүүлэн авч 16.8 сая төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 7.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 11.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан. Тус аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Буянт сумын 4 дүгээр багийн Шар тохойд байршилтай 20,667 м2 газрыг 41.3 сая төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 401 тоот тогтоолоор 22.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.6 сая төгрөгийн тавилгыг акталж, 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 450 тоот тогтоолоор 87.1 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгосны дагуу данс бүртгэлээс хасаж, худалдсан хөрөнгийн орлогыг өмч хувьчлалын орлогын төрийн сангийн дансанд тушаасан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 8.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 809.1 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 809.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 37.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.8 сая, байр ашиглалттай холбоотой зардлыг 34.2 сая, хангамж бараа материалын зардлыг 45.4 сая, норматив зардлыг 12.3 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 63.6 сая, томилолт, зочны зардлыг 4.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, үйлчилгээний бусад зардлыг 1.5 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 5.2 сая, бусад шилжүүлгийн зардлыг 0.1 сая, нийт 205.6 сая төгрөгөөр бууруулж, 603.6 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 326.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 929.7 сая төгрөгөөр тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 929.7 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 926.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 926.9 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 2.7 сая төгрөгөөр хэмнэж улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 901,091.4 | 898,338.6 | 2,752.8 | 99.7 |
| 2 | Холбооны суваг ашигласны хөлс | 942.4 | 942.4 | - | 100.0 |
| 3 | Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ | 8,800.0 | 8,800.0 | - | 100.0 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 18,852.4 | 18,852.4 | - | 100.0 |
| | **Дүн** | **929,686.2** | **926,933.4** | **2,752.8** | 99.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ерөнхий газраас дээврийн засварт 3.7 сая төгрөгийн, Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас цагдан хорих өрөөний тохижилтын ажилд 10.0 сая төгрөгийн, мод тариалах зардалд 3.0 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгийн төсвөөс байрны түрээсийн зардалд 6.0 сая төгрөгийн, байгууллагын 4810БӨТ улсын дугаартай, Пургон машины засварын зардалд 2.9 сая төгрөгийн, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас “Гэмтэй ч гэртээ” төсөлд 10.0 сая төгрөгийн, албадан эмчлэх 3 хүний шатахууны зардалд 3.0 сая төгрөгийн, нийт 38.6 сая төгрөгийн төсвийг нэмэлт дансаар хүлээн авч зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 96.8 сая төгрөгийн бараа материал, 11.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/101 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 677.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,018.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 882.3 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32.4 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч,

хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 52.5 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 23.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 18.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1185.5 | 1 | 1185.5 | 100 |
| Албан шаардлага | 1 | 3180.0 | 1 | 3180.0 | 100 |
| Зөвлөмж | 3 | 18910.4 | 3 | 18910.4 | 100 |
| **Нийт дүн** | **5** | **23275.9** | **5** | **23275.9** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, алдаа зөрчил илрээгүй болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |